



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/7/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: Б.Одхүү
Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	4
2. Аудитын тайлан	6
2.1. Оршил	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө.....	8
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	9
2.8.3 Авлага.....	9
2.8.4 Урьдчилгаа.....	10
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	10
2.8.6 Бараа материал	10
2.8.7 Үндсэн хөрөнгө	10
2.8.8 Өр төлбөр	11
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
1. Менежментийн захидал	14
3.1 засаг даргын нөөцийн хөрөнгөтэй холбоотой асуудал	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	24
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ

		СЭРГЭЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА Н.ГҮРРАГЧАА ТАНАА	
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР			
21000, Дорнод аймаг, Хэргэн сум 7-р баг ЗДТТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203			
2020.03.25 № 332			
танай	-ны №	-т	
Аудитын гэрчилгээ			
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сэргэлэн сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.			
Зөрчилгүй санал дүгнэлт			
Сэргэлэн сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.			
Санал дүгнэлтийн үндэслэл			
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.			
Аудитаар Сэргэлэн сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.			
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.			
110520270			



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Н.Гүррагчаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэргэлэн сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж гүйцэтгэв.

Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/104 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Сэргэлэн сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Сэргэлэн сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Сэргэлэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Сэргэлэн сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардал 1,723.0 сая төгрөгийн 2 хувь буюу 34.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 45.0 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллага аудитад хамрагдсан.



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 6 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт өгч, 3 байгууллагын тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

- Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 69,888.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, 69,312.3 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага, зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр 203,700.0 мянган төгрөгийн 16 хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр батлагдсанаас, санхүүжилт оройтож ирснээс 69,312.3 мянган төгрөгийн 8 төсөл арга хэмжээ хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 41.2, 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 78,406.9 мянган төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- Сэргэлэн сумын Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ: Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоогүй байсан тул тайланд элэгдлийн зардал 50,698.2 мянган төгрөгийг залруулах бичилт хийв.
- Сэргэлэн сумын ЕБС: Д.Туулд илүү цалин олгосон цалингийн буцаалтыг бичилт хийхдээ зардлын дансыг КТ-д бичсэн 439,8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулсан.
- Сэргэлэн сумын ЕБС: Нэмэлт дансаар орсон 200.0 мянган төгрөгийн орлогыг урсгал санхүүжилтаар тусгасныг санхүүгийн тайланд залруулсан.
- Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв: Шилжүүлж өгсөн эмнэлгийн хэрэгслийн 6,392.2 мянган төгрөгийг санхүүгийн тайлан бүртгэлд тусгуулж санхүүгийн тайланд залруулга хийлээ.
- Сэргэлэн сумын Соёлын төв: Хураангуй бүртгэлийг дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгахад 20,676.7 мян төгрөгийн ҮХ-ийг бараа материалд бүртгэсэн байсныг санхүүгийн тайланд залруулсан.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 81.7 сая, эцсийн үлдэгдэл 199.7 сая төгрөг болж, 118.0 сая Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 81.7 сая, эцсийн үлдэгдэл 199.7 сая төгрөг болж, 118.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

ДОА-2020/7/СТА-ТТЗ



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
Төрийн банканд <u>байгаа бэлэн мөнгө</u>	81.2	199.5	118.3	
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	0.5	0.2	-0.3	
<u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u>				
<u>Хадгаламж</u>				
<u>Дүн</u>	81.7	199.7	118.0	144%

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 199.5 сая төгрөгөөс төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 199.5 сая төгрөг, арилжааны банкны дансанд 0.2 сая төгрөг байршиж байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

2.8.3 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 195.5 сая, эцсийн үлдэгдэл 186.1 сая төгрөг болж 9.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.0		
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээл, зээлийн хүүгийн авлага	174.8	167.4	-9.4
Бусад авлага	18.7	18.7	0
Зээлийн авлага			
<u>Дүн</u>	195.5	186.1	-9.4

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 186,1 сая төгрөгийн дараах авлага байна.
Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн 0-1 жилийн насжилттай 50.5 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 1-2 жилийн насжилттай 10.5 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 2-3 жилийн насжилттай 60.6 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 3-4 жилийн насжилттай 23.8 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 4-5 жилийн насжилттай 8.4 сая төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 5-аас дээш жилийн насжилттай 13.6 сая төгрөгийн авлага
- Орон нутгийн хөгжлийн сангийн 5-аас дээш жилийн насжилттай 18.7 сая төгрөгийн авлага байна

Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү болон алдангийг сумаас мэдэгдэх хуудас өгөх, шүүхэд шилжүүлэн ажилласан байна.

Зээлийн төлбөрөө хугацаандаа төлөөгүйн улмаас дараа дараагийн зээлийн олголтод сөрөг үр дагавартай байна.



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа
данс үлдэгдэлгүй байна.

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын
данс
үлдэгдэлгүй байна.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын
эхний үлдэгдэл 323.9 сая.
эцсийн үлдэгдэл 378.0 сая төгрөг болж 54.1 сая төгрөгөөр өссөн байна.
Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	220.6	273.1	52.5
Түүхий эд материал	0.8	2.4	1.6
Мал	102.5	102.5	
Дүн	323.9	378.0	54.1

Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа
материал байхгүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл
4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 3,239.1 сая,
эцсийн үлдэгдэл 3,782.5 сая төгрөг болж, 543.4 сая төгрөгөөр өссөн байна.
Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	3,058.6	3,602.0	543.4
Биет бус хөрөнгө	180.5	180.5	0
Н	3,239.1	3,782.5	543.4

Тайлант онд 48.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 9.3 сая төгрөгийн хөрөнгийг
балансаас балансад шилжүүлж, үнэ төлбөргүйгээр 528.7 сая төгрөгийн хөрөнгө аван нийт
586.8 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад 9.3 сая төгрөгийг шилжүүлж, 34.1 сая
төгрөгийн хөрөнгийг акталж нийт 43.4 сая төгрөгөөр хасагдсан байна.



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.5 сая төгрөг байсан бол жилийн эцэст үлдэгдэлгүй болсон байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн		0.5		
Урт хугацаат өр төлбөр дүн				
Нийт дүн		0.5		

Өр төлбөрийн данс үлдэгдэлгүй байна

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,184.0 сая, эцсийн үлдэгдэл 3,721.6 сая төгрөг болж өмнөх оноос 537.6 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалттай холбоотой байна.

Хүснэгт № 31. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,657.8	1,657.8		
Өмч /төрийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувийн/ /ТӨҮГ/				
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/				
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/				
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/				
Хуримтлагдсан үр дүн	524.4	1,062.2	537.8	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,001.8	1,001.8		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга				
Дүн	3,184.0	3,721.6	537.6	116.9

Засгийн газрын оруулсан капитал болон хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

ДОА-2020/7/СТА-ТТЗ

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Right, Space After: 0 pt



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сэргэлэн сумын ИТХ-ын 2018 оны орон нутгийн төсөв батлах тухай 04 дүгээр тогтоолд зааснаар тайлант онд 39.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 72.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 184.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	0.4	1.3	0.9	332.1
Шууд бус орлого	19.0	22.4	3.4	118
Бууны албан татвар	1.4	1.4		99.9
Улсын тэмдэгийн хураамж	1.5	0.8	-0.7	51.2
Газрын дуудлага худалдааны орлого	0.8		-0.8	
Хүүгийн орлого	9.5	12.7	3.2	134.1
Торгуулийн орлого	4.2	0.8	-3.4	19.9
Бусад орлого	2.5	33.0	30.5	1314.4
Нийт дүн	39.3	72.4	33.1	184.1

Төсвийн нийт орлого 33.1 сая төгрөгөөр давсан нь үйл ажиллагааны орлого, хүүгийн орлого, бусад орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,934.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,465.4 сая төгрөгийг урсгал зардалд, 227.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэн төлөгдөх зээл 241.9 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 884.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 660.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 19.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 369.8 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 868.1 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 607.6 сая төгрөгийг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 9.0 сая төгрөгийг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 102.3 сая төгрөгийг, бусад эх үүсвэрээс 9.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч 62.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 10.9 сая төгрөг дутуу буюу гүйцэтгэлээрээ олгогдсон, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 265.2 сая төгрөгөөр дутуу орсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 0.6 сая төгрөгөөр тасарсан нь ЗДТГ-т өөрийн орлогоо бүрдүүлэх үйл ажиллагаа хязгаарлагдмал, канон принтерийн үйл ажиллагаа бага, хадлангийн орлого нэмэлт дансаар дамжиж байгаагаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,559.6 мянган төгрөг буюу 80.6 хувьтай байгаа нь Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, туслах үйл



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлсэн мөн ОНХС-гийн хандивын санхүүжилт удааширснаас шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээнд 203.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 187.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 134.4 сая төгрөгийг хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж төрийн сангийн дансанд 53.5 сая төгрөг үлдсэн байна..

Нэмэлт төсөв: Нэмэлт төсвийг дээд шатны төсвийн захирагчаас 35.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 5.6 сая төгрөг, нийт 41.2 сая төгрөгийн орлогоос бүрдүүлжээ.

Үүнээс: Хангамжийн бараа материалын зардалд 1.2 сая төгрөгийг, нормативт зардал 0.3 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 18.7 сая төгрөгийг, эд хогшил урсгал зардалд 0.6 сая төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 0.2 сая төгрөгийг, урамшуулалд 0,2 сая төгрөгийг, өвс тэжээлийн нөөцөд 20.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумдын Засаг дарга нар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс, журамд зөвшөөрөгдөөгүй арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Сэргэлэн сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 134 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Үүнд: Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ болон ОНӨО-ын 1, 3 сарын мэдээллийг хоцроосон байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсний биелэлтийг 2019 оны 06 дугаар сарын 31-ний өдрийн 01/168 тоот албан бичиг, 2019 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/188 тоот албан бичиг, 2019 оны 12 дугаар сарын 20-ны 01/316 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Сэргэлэн сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



1. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦИЙН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт: ИТХ нь нийт худалдан авалтын 5.6 хувь буюу 576.0 мянган төгрөгийн е-баримтыг анхан шатны баримт болгон хавсаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 дахь заалт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм." гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж: Хууль журмыг мөрдөн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	601 091 237,80	763 731 364,93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	81 731 931,03	199 666 853,27
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	81 731 931,03	199 666 853,27
3121	Төгрөг	81 731 931,03	199 666 853,27
31211	Төрийн сангийн харилцах	81 243 185,99	199 451 141,23
31213	Арилжааны банк дахь харилцах	488 745,04	215 712,04
33	АВЛАГА	195 504 721,34	186 076 499,00
335	Бусад авлага	193 465 983,00	186 076 499,00
3351	Байгууллагаас авах авлага	18 702 300,00	18 702 300,00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	174 763 683,00	167 374 199,00
35	БАРАА МАТЕРИАЛ	323 854 585,43	377 988 012,66
351	Түүхий эд материал	752 255,15	2 356 581,68
35110	Тусгай зориулалттай материал	478 318,00	478 318,00
35130	Эм боох материал	273 937,15	1 878 263,68
354	Хангамжийн материал	220 557 230,28	273 086 330,98
35410	Бичиг хэргийн материал	2 874 977,50	4 656 289,50
35420	Аж ахуйн материал	100 798 518,90	136 885 269,90
35430	Сэлбэг хэрэгсэл	436 500,00	590 500,00
35440	Түлш, шатах тослох материал	7 349 252,00	14 563 449,00
35460	Хүнсний материал	544 730,00	337 100,00
35470	Бусад хангамжийн материал	108 553 251,88	116 053 722,58
35600	Мал амьтад	102 545 100,00	102 545 100,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2 583 413 324,40	2 958 023 935,83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 583 413 324,40	2 958 023 935,83
392	Биет хөрөнгө	2 402 285 573,82	2 777 334 352,51
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 651 538 872,32	1 866 503 871,32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(8 615 238,84)	(65 535 440,04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155 742 916,00	148 691 634,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(86 375 358,60)	(99 645 126,61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	402 329 796,96	448 476 031,56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(191 177 585,61)	(224 672 565,10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	195 075 575,08	194 798 808,48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(82 508 708,10)	(87 956 874,40)
39209	Зам, гүүрийн байгууламж	47 974 987,00	152 338 438,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(23 785 959,88)	(29 527 025,08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	602 769 166,00	786 364 714,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(260 682 888,51)	(312 502 113,62)
393	Биет бус хөрөнгө	181 127 750,58	180 689 583,32
39301	Програм хангамж	3 211 171,00	4 893 371,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2 557 420,42)	(2 677 787,64)
39303	Бусад биет бус хөрөнгө	180 474 000,00	180 474 000,00
39304	Хуримтлагдсан элэгдэл		(2 000 000,04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III+II	3 184 504 562,20	3 721 755 300,76
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3 184 025 047,20	3 721 755 300,76
51	Засгийн газрын хувь оролцоо	3 184 025 047,20	3 721 755 300,76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 657 787 772,85	1 657 787 772,85
512	Хуримтлагдсан үр дүн	524 449 724,16	1 062 179 977,72
51210	Өмнөх үеийн үр дүн	422 993 944,66	524 449 724,16
51220	Тайлант үеийн үр дүн	101 455 779,50	537 730 253,56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 001 787 550,19	1 001 787 550,19



Сэргэлэн сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3 184 504 562,20	3 721 755 300,76
---	--	------------------	------------------

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 873 438 599,65	2 850 172 905,82
11	ТАТВАРЫН ОРЛОГО	20 577 393,86	25 921 697,32
